

ХОВД АЙМГИЙН МЯНГАД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗАР

[ ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ҮДИЙН ЦАЙ ] СОНГОН ШАЛГАРУУЛАХ  
ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ

Тендер  
шалгаруулалтын нэр:

Ерөнхий боловсролын сургуулийн Үдийн цай  
сонгон шалгаруулах

Тендерийн дугаар: ХОАМЯСЗДТГ/20200001/

## ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо 2019.01.28

Тендер шалгаруулалтын нэр: [Ерөнхий боловсролын сургуулийн Үдийн цай сонгон шалгаруулах](#)

Тендэр шалгаруулалтын дугаар: ХОАМЯСЗДТГ/20200001

Санхүүгийн эх үүсвэр: [Улсын төсөв- 35.320.000 төгрөг](#)

Ховд аймгийн Мянгад сумын Засаг даргын тамгын газар нь сонгогдсон эрх бүхий тендер оролцогчдоос : “ [Ерөнхий боловсролын сургуулийн Үдийн цай сонгон шалгаруулах](#) ” үйлчилгээ үзүүлэх тухай битүүмжлэл бүхий тендер ирүүлэхийг урьж байна. Үнийн санал ирүүлэх ажлын зураг, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно. Үнийн саналыг [2020 оны 02 сарын 06-ны өдрийн 10 цаг 30 минут-с өмнө \[ЗДТГазар санхүү албаны өрөө, худалдан авах ажиллагаа хариуцсан ажилтан С.Ганхуяг утас 99315595\]](#) хаягаар ирүүлнэ. Цахим тендер бол цахим системээр ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан [2020 оны 02 сарын 06-ны өдрийн 11 цаг 30 минут-т](#) нээнэ. Дотоодын давуу эрх тооцох эсэх: [Тооцно](#)

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

[Ховд аймгийн Мянгад сумын ЗДТГ-ын санхүү албаны өрөө](#)  
Утас, Факс: 99315595  
Имэйл хаяг: [Gankhuyag86@yahoo.com](mailto:Gankhuyag86@yahoo.com)

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа
  2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт
  3. Тендерийн иж бүрдэл
  4. Тогтмол үнэ
  5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд
  6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа
  7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
- 1.1.Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
  - 2.1.Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
  - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
  - 3.1.Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
    - (а) Үнийн санал;
    - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
    - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
    - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
    - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
  - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
  - 5.1.Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
  - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
  - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
  - 7.1.Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
  - 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
  - 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

**8. Гэрээ  
байгуулах эрх  
олгох тухай  
мэдэгдэл**

8.1.Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

**Гурав.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

Худалдан авах барааны талаарх дор дурдсан өгөгдлүүд нь тендерт оролцогчид өгөх зааварчилгаа /ТӨӨЗ/-ны холбогдох зүйл, заалттай мэдээллийг гүйцээх, нэмэлт оруулах, эсхүл өөрчлөх зорилготой. Хэрэв ТӨӨЗ-ны зүйл, заалттай зөрчилдвөл энэхүү хүснэгт дэх мэдээллийг зөв гэж үзнэ.

<b>ТӨӨЗ-ны холбогдох заалт</b>	<b>А. Ерөнхий зүйл</b>
<b>ТӨӨЗ 1.1</b>	Захиалагч нь <b>Ховд аймгийн Мянгад сумын ерөнхий боловсролын сургууль</b>
<b>ТӨӨЗ 1.2</b>	Нээлттэй тендер шалгаруулалтын нэр болон ялгагдах дугаар : <b>Ерөнхий боловсролын “Үдийн цай”</b>
<b>ТӨӨЗ 1.3</b>	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах ажлын даалгавартай <ul style="list-style-type: none"> <li>- <b>Үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй.</b></li> <li>- <b>Үйл ажиллагаа явуулж байсан дадлага туршлагатай</b></li> <li>- <b>Эрүүл ахуйн шаардлага хангасан дулаан тохилог байртай байх</b></li> <li>- <b>Бүтээгдэхүүн хийх тоног төхөөрөмжийн нэр төрөл болон тоо хүрэлцээтэй байх</b></li> <li>- <b>Хүнсний бүтээгдэхүүн хийх мэргэжлийн тогоочтой байх</b></li> <li>- <b>Хүнсний бүтээгдэхүүн нь хүүхдэд таарсан илч калори агуулсан байх.</b></li> <li>- <b>Ажиллах хүчин нь эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан байх</b></li> <li>- <b>Хүнсний бүтээгдэхүүн нь мэргэжлийн хяналтын шинжилгээнд орсон байх</b></li> </ul>
<b>ТӨӨЗ 2.1</b>	Санхүүжилтийн эх үүсвэр нь: <b>Улсын төсвийн хөрөнгө төсөвт өртөг: 35,320,000 төгрөг</b>
	<b>Б. Тендерийн баримт бичиг</b>
<b>ТӨӨЗ 8.1</b>	Захиалагчаас тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга авах хаяг: <b>Мянгад сумын Ерөнхий боловсролын сургууль</b> <b>утас : 94009911 94700307</b>
<b>ТӨӨЗ 8.2</b>	Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын <b>5 хоногоос багагүй</b> байна.
<b>ТӨӨЗ 11</b>	<b>В.Тендер бэлтгэх.</b>
<b>ТӨӨЗ 11.1</b>	Тендерийг <b>Монгол хэл</b> дээр бэлтгэнэ.
<b>ТӨӨЗ 11.2</b>	Тендерт оролцогч дараах нэмэлт материалыг өөрийн тендерт хавсралтаар ирүүлнэ. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>- <b>Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар / Нотариатаар баталгаажуулсан/</b></li> <li>- <b>Татварын албаны тодорхойлолт</b></li> <li>- <b>Банк, санхүүгийн байгууллагаас хугацаа хэтэрсэн өр төлбөргүй</b></li> </ul>

	<p>эсэх тодорхойлолт</p> <ul style="list-style-type: none"> <li>- Харилцагч банкны харилцах дансны хуулга / сүүлийн зургаан сараар /</li> <li>- Шүүх болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны тодорхойлолт</li> <li>- Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт</li> <li>- Бараа нийлүүлэх хуваарь /Маягтын дагуу/</li> <li>- Хэрэгжүүлж байгаа болон хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээлэл</li> <li>- Техникийн тодорхойлолтын ерөнхий шаардлагын хэсэгт шаардсан бусад материалууд</li> </ul>
ТӨӨЗ 14.1	Хувилбарт тендер ирүүлэхийг “зөвшөөрөхгүй”
ТӨӨЗ 15.5	Олон улсын худалдааны /Инкотермс-ийн хувилбар: шаардлагагүй
ТӨӨЗ 15.9 б	Бараа хүргэгдэх газар: <b>Ховд аймаг Мянгад сумын Ерөнхий боловсролын сургууль</b>
ТӨӨЗ 15.10	Тендер оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад <b>тохируулахгүй тогтмол</b> байна.
ТӨӨЗ 16.1	Тендерийн валют биш <b>төгрөг</b> байна
ТӨӨЗ 18.1 а	Барааг хаанаас, хэрхэн нийлүүлэх талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, <b>холбогдох баримт материалыг тендерийн хамт ирүүлнэ.</b>
ТӨӨЗ 18.1 б	Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: <b>2018-2019 оны жилийн эцсийн тайлан</b>
ТӨӨЗ 18.1 г	Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: <b>1 жил</b>
ТӨӨЗ 18.2 А	Борлуулалтын хэмжээ: <b>50 хувь</b>
ТӨӨЗ 18.2 б	Гүйцэтгэгчээр ажилласан байх жилийн тоо: <b>1 жил</b>
ТӨӨЗ 18.4 д	Дотоодын давуу эрх: <b>Тооцох</b>
ТӨӨЗ 19.1 б	Баталгаат хугацаа : <b>1 жил</b>
ТӨӨЗ 20.1	Тендер нээснээс хойш <b>5 хоногийн</b> туршид хүчинтэй байна.
	<b>Г.Тендер ирүүлэх</b>
ТӨӨЗ 23.3 б	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <b>[ЗДТГазар]</b>  Давхар болон өрөөний дугаар: <b>ЗДТГазар, 1 давхарт №1 Санхүү албаны өрөө утас 99315595</b></p> <p>Огноо: <b>[2020 оны 02 сарын 06 өдөр]</b></p> <p>Цаг: <b>[10 цаг, 30 минут]</b></p>
	<b>Д. Тендерийг нээх үнэлэх</b>
ТӨӨЗ 28.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <b>[ЗДТГазар, 1 давхарт № 1 Санхүү албаны өрөө Утас 99315595</b></p> <p>Огноо: <b>[2020 оны 02 сарын 06 өдөр]</b></p> <p>Цаг: <b>[11 цаг, 30 минут]</b></p>
ТӨӨЗ 6.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>[Багц байхгүй]</b>

БАТЛАВ  
ЗАХИРАЛ Ж.БАТСАЙХАН

МЯНГАД СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН "ҮДИЙН ЦАЙ"-НЫ  
АЖЛЫН ДААЛГАВАР

ДД	Махны төрөл	Тоо ширхэг	Үзүүлэлт
1	Үдийн цай	35,320.000 төг	1.Үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй. 2.Үйл ажиллагаа явуулж байсан дадлага туршлагатай. 3.Эрүүлахуйн шаардлага хангасан дулаан тохилог байртай. 4.Бүтээгдэхүүн хийх тоног төхөөрөмжийн нэр төрөл болон тоо хүрэлцээтэй. 5.Хүнсний бүтээгдэхүүн хийх мэргэжлийн тогоочтой байх. 6.Хүнсний бүтээгдэхүүн нь хүүхдэд таарсан илч ,калори агуулсан байх. 7.Ажиллах хүчин нь эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан байх. 8.Хүнсний бүтээгдэхүүн нь мэргэжлийн хяналтын шинжилгээнд орсон байх.

БОЛОВСРУУЛСАН  
НЯРАВ Б.ПҮРЭВДОРЖ  
ЗӨВШИЛЦСӨН

СУРГАЛТЫН МЕНЕЖЕР Д.ХИШГЭЭ

## 5.Бараа нийлүүлэлтийн хуваарь:

### БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхой лолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
<i>ЕБС үдийн цай</i>		<i>Багцгүй</i>			<i>2020.01.31</i>	<i>2021.01.31</i>	

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

**1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**  
[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг **[санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр]** төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Хэмжих нэгж	Нэгжийн үнэ	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд үнэ
Мах			хамаарахгүй				
Сүү, сүүн бүтээгдэхүүн							
Гурил, гурилан бүтээгдэхүүн							
<b>Нийт дүн</b>							

Баталгаат засварын хугацаа:

- Санал болгож буй бусад нөхцөл  
Тендерт оролцогчийн нэр:



Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхгүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- 1. Шалгах болон турших** 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
- 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт** 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
- 3. Оюуны өмчийн эрх** 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
- 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх** 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
- 5. Баталгаат засварын хугацаа** 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа **[0,6]** жил байна
- 6. Гэрээнд өөрчлөлт оруулах** 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөлтөөрчлөхгүй.
- 7. Төлбөр** 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш **[7]** хоногийн дотор шуурхай хийнэ.
- 8. Бараа нийлүүлэх хуваарь** 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
- 9. Алданги оногдуулах** 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
- 10. Үүргээ биелүүлээгч гэрээг цуцлах** 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
- 11. Маргааныг шийдвэрлэх** 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. **Шалгах**1.1. [Халамжийн байцаагч Д.Хандармаа, захиалагч байгууллагаас болон турших (ГЕН – 1) гэрээний хэрэгжилтэнд хяналт хийж болно]

2. **Барааны**2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:  
**нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт** (ГЕН – 2)

- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
- 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
- 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
- 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
- 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.

Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.

3. **Баталгаат**5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.  
**засвар** (ГЕН-5)

[Хүнсний бүтээгдэхүүн учир бүтээгдэхүүн тус бүрийн чанарын баталгаа нь үйлдвэрийн хугацаатай байна.]

4. **Төлбөр**7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:

Гэрээний үнийн дүнгийн **[Сар бүр олгогдсон хүнсний эрхийн бичгийн дагуу тооцоо хийх болно.]** хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.

5. **Алданги**9.1. Алданги оногдуулах хувь: **[0,02]**  
**оногдуулах** (ГЕН - 9)<sup>1</sup>

Алдангийн нийт дүн: **[0,1]**

---

Долоо. **ГЭРЭЭНИЙ МАЯГТ  
БАТЛАВ.**

**ЗАХИАЛАГЧ**

**НИЙЛҮҮЛЭГЧ**

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)

\_\_\_\_\_  
(Гарын үсэг)

\_\_\_\_\_  
(Гарын үсэг)

\_\_\_\_\_  
(Албан тушаал)

\_\_\_\_\_  
(Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_ сарын \_\_\_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_-наас \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>2</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

<sup>2</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*

*[Албан тушаал, нэр]*

*[Гарын үсэг]* \_\_\_\_\_

*[Гарын үсэг]* \_\_\_\_\_

ТАМГА

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*

*[Захиалагчийн хаяг]*

*[Утас/факсын дугаар]*

*[Утас/факсын дугаар]*

*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

